

## Хэсэг 14

### **Бага ястан хэмээх зохиомол нэр томъёо: Монгол дахь хүний эрх ба соёлын ялгаварлан гадуурхалт**

Баатаржавын Бат-Амгалан

*Редакторын тайлбар:* Үндэстний цөөнхийн хэл, хэл зүйг үл ойшоох байдал дэлхийн улс орнууд, тэр дундаа Монголд хөндөн хэлэлцэх асуудлын нэг ажээ. Түүний илтгэж танилцуулснаар “жижиг”, бага гэсэн утга агуулах “бага ястан” гэх нэр томъёо нь баруун Монголчуудын хувьд үл тоомсорлосон, эрх нөлөө багатай гэсэн утга санаа агуулж байдаг байна. Баруун Монголчуудын хэл ярианы хэлбэр нь өнөөгийн төв халх аялгатай харьцуулахад эртний монгол хэл, бичигтэй илүү ойр төстэй юм.

Б.Бат-Амгалан баруун Монголчуудын хэл, соёлын орхигдлын талаар “Монголын дотоодод болон гадаадад байгаа Монгол угсаатныг үл хайхрах асуудал нь анхаарал хандуулах шаардлагатай чухал сэдэв бөгөөд интернетээр дамжих ташаа мэдээлэл нь залуучуудад сөргөөр нөлөөлж байна” гэж үзсэн байна. Тэрээр эдгээрийг дүгнэж эрдэмтдийг энэхүү ташаа ойлголтыг залруулж, баруун Монголчуудыг бусдаас өөр, хаягдмал мэтээр бус, харин эсрэгээр баруун болон бусад Монголчуудын хэл яриа, зан заншлын хэрхэн нэгдмэл болох тухай сурталчлан таниулж байхыг уриалсан байна.

Б.Бат-Амгалан энэхүү уриалгаа эрдэмтэд, иргэний болон улс төр, шашны манлайлагчдад хүргэх боломж олгосонд талархсанаа илэрхийлжээ.

---

Ардчилсан хувьсгал тайван замаар ялсан 1990 оноос хойшхи хорин жилийн хугацаанд Монгол улсын өмнө олон ноцтой сорилт тулгарч байсан. Харин сэтгэл санааны болон соёлын ул суурьтай бөгөөд өргөн хүрээтэй өөрчлөлтүүдийн

явцад манай улс үндэстэн дийлэнхдээ амжилт олж, эерэг үр дүнд хүрсэн нь бахархууштай. Хамгийн хэцүү, бэрхшээл ихтэй нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоог халж, зах зээлийн харилцааг төлөвшүүлэх эдийн засгийн шилжилт байсан гэдэгтэй хэн ч маргахгүй. Одоо хүн бүр л, ялангуяа манай эдийн засагчид шилжилтийн үеийн ололт, амжилтыг өөр өөрийнхөөр үнэлж хэлэлцэж байна. Харин өнөөдрийг хүртэл ойлголт хандлагын ямар өөрчлөлтүүд гарч, ямар нөлөө үзүүлээд, цаашид тулгарах сорилт, бэрхшээлийг даван туулах улс үндэстний чадвар, чадавхид хэрхэн нөлөөлөхийг судалж ойлгох нь нийгмийн шинжлэх ухааны салбарт ажиллаж буй бидний хийх ёстой ажил юм.

1990 оноос хойш албан бус хийгээд буруу ташаа ойлгогдохуйц нэгэн нэр томъёог Улаанбаатар болон Монгол даяар улам их хэрэглэх болжээ. Энэ бол Монголын баруун хязгаарын ард түмнийг үндэсний цөөнх буюу “бага ястан” гэж нэрлэх явдал юм. Бага ястан хэмээх нэр томъёог бүх хүн, тэр бүү хэл баруун аймгийнхан өөрсдөө ч бүр социализмын үеэс л хэрэглэдэг байсан ч сүүлийн үед аман ярианы энэ хэллэгийг албан ёсны нэр томъёо мэт хэрэглэх болжээ. “Бага ястан” гэдэг нь Орос хэлний *малый народ* гэдэг хэллэгийн хадмал орчуулга гэж би харж байгаа бөгөөд энэ хэллэг нь мөн чанартаа “цөөнх ард түмэн” гэсэн утгатай билээ. Харин утгыг нь ухааж ойлголгүй хадаж орчуулснаас болж Монгол хэлэнд утга нь үл ойшоосон өнгө аястай, чадавхи дутуу гэсэн мэт утга агуулгатай болж бүрэн хувиран, энэ нь бага ястан гэж тооцогддог голдуу Увс, Ховд, Баян-Өлгий аймгийнханд ичих, эргэлзэх сэтгэл төрүүлэх болжээ.

Говь-Алтай, Завхан, Хөвсгөлийг мөн багтаасан Монголын баруун бүс нь уламжлалт амьдралын хэв маяг, зочломтгой зан чанарыг хадгалахад үнэлж баршгүй хувь нэмэр оруулж байгаа. Эдгээр аймаг нь Монголын бусад бүс нутагтай харьцуулахад соёл, шашин, хэлний өвөрмөц онцлогоо

уламжлан хадгалж чадсаныг судлаачид юу юуны өмнө онцлон тэмдэглэдэг. Хамгийн чухал нь, Баруун Монголд хамгийн сайн хадгалагдаж үлдсэн эртний монгол аялга орчин үед хэрхэн өөрчлөгдөн хувирч байгааг судлан тогтооход баруун Монгол шүлэг, дуу, үлгэр, домог нь судалгааны эх сурвалж болдог. “Бага ястны” хэл гэж нэрлэгдээд байгаа энэ хэл нь үнэн хэрэгтээ энэ бол баруун Монголын Ойрад овгууд болох Торгууд, Дөрвөд, Мянгад, Өөлд, Захчин, Хошууд, Урианхай, Тува нарын хэлэнд өвлөгдөн үлдсэн эртний Монгол хэл юм.

Судлаач, эрдэмтдийн ихэнх нь энэ хэлийг хуучин монгол бичигт тусгал, илэрхийллээ олсон эртний монгол хэлний шууд залгамжлагч гэдгийг мэдэж байгаа нөхцөлд түүнийг үндэсний цөөнхийн буюу бага ястны хэл гэж нэрлэх нь шударга бус юм. Хуучин монгол бичиг бол Монгол үндэстний анхдагч босоо бичиг, Чингис хааны байгуулсан их эзэнт гүрний бичиг байсныг бид бүгд мэднэ. Тиймээс Монгол бол нэг үндэстэн бөгөөд зөвхөн өнөөгийн нутаг дэвсгэрийн хил заагаар хязгаарлагдахгүй түүхэн олон үйл явдал, учир шалтгааны улмаас гадаадад амьдарч байгаа Монгол хүмүүсийг ч багтаасан ойлголт гэдгийг бид мартаж аргагүй.

Харамсалтай нь баруун аймагт амьдарч буй олон хүн энэхүү буруу нэр томъёоны гарал үүсэл, эх сурвалжийг ойлгож мэдэхгүй, зарим нь бүр албан ёсны нэр томъёо, тодорхойлолт мэт хүлээж авах болж, ялангуяа залуучууд баруун Монгол аялгаасаа, өөрийн төрөлх хэлнээсээ ичих болжээ. Эдгээр хүмүүс үнэндээ ам дамжсан ярианаас үүдэлтэй далд бөгөөд зорилготой нөлөөлөл буюу XIX-XX зуунд Монголчуудын нэгдэн нийлэх хүсэл эрмэлзлийг таслан зогсоох зорилгоор Манжийн эзэнт гүрний хэрэгжүүлсэн нарийн ухаан, стратегийн нөлөөлөлд автан ийнхүү эх хэл, аялгаасаа ичих болсон юм.

Өнөөдөр энэ мэхлэлтээс үүдэлтэй олон эмгэнэлт үр дагавар нийгмийн амьдралд илэрсээр байгаа бөгөөд ялангуяа Монголын баруун бүс нутгийн залуучууд аялгаасаа ичиж,

ялгаварлан гадуурхагдахаас эмээж байна. Энэ бол эртний Монгол хэл гэдгийг тэд мэдэхгүй ч эрдэмтэн судлаачид сайн мэдэж байгаа. Монголдоо өөрийн эх орондоо “бага ястан”, “үндэсний цөөнх” гэж дуудуулж байгаа эдгээр залуус Монгол гарвалтай эсэхдээ ч эргэлзэж эхэлж байна. Энэ асуудал интернетийн виртуал орчинд тодорхой ажиглагдах бөгөөд тухайлбал, та “Халх монгол”, “Ойрад монгол” гэж хайгаад үзээрэй.

Энэ хүрээд миний бие 2006 онд дөрвөн залуутай хамтран Тод Номын Гэрэл Төвийг хэрхэн байгуулсан тухай өгүүлбэ. Би 1992 онд МУИС-аас зохион байгуулсан их сургуулиудын эрдэм шинжилгээний хурал дээр Надмидын Сүхбаатартай анх таарч, “жирийн бус” аялгаараа бусдаас ялгаран танилцсан юм. Илтгэлээс нь би түүнийг баруун аймгаас ирсэн түүхийн ангийн нэгдүгээр курсийн оюутан болохыг мэдсэн юм.

Дээд сургуульд сурч байхад бусад оюутнууд биднийг хаа ч явсан ялган таньдаг байв. Тэд биднийг Увсынхны хэлээр ярихыг хүсэж, инээлддэг байсан. Бид ч өөрсдийгөө Монгол хэлээр ярьдагийг батлах, тэдний аман яриаг төвөггүй ойлгож байгаагаа харуулах гэж хэрээрээ хичээдэг байсан. “Чи Ховдынх уу, Увсынх уу?” “Бага ястан хэлээрээ ярьж үзүүлээч” “Дөрвөд хэлээр энийг юу гэдэг вэ?” зэрэг асуулт байнга тавьдаг байсан.

Залуу байхдаа оюутан биднийг ялгаварлан гадуурхаж, үл тоомсорлож буйг сэтгэл зүрхэндээ мэдэрч, эх Монгол хэлээрээ ярихаасаа ичин бэрхшээдэг байсан. Түүнээс арван зургаан жилийн дараа Оросын Халимаг улсад анх зочилж байхдаа, дараа нь Волгоград, Москва хотод байхдаа мөн ижил сэтгэл төрж байсан билээ. Монгол дээл өмссөн намайг бусад хүмүүс жинхэнэ үндэсний цөөнх гэж хүлээн авч, тэр ч бүү хэл цагдаа нар байнга зогсоон шалгаж байсан. Том үндэстний дотор угсаа үндсээрээ ялгаатай цөөнх нь байх ямар хэцүү болохыг би үнэхээр сайн ойлгож байна.

Харамсалтай нь яг ийм байдал Монголд байсаар л байна.

Бага ястан хэмээх буруу нэр томъёо ашиглагдахаар барахгүй түүхийн мэдлэг сулхан залуу үе маань интернетийн мэдээлэлд найддаг болсноор хэрэглээ нь улам ч нэмэгдээд байх шиг санагддаг болов. Улс төрч, цагдаа, сургуулийн хүүхэд, лам хувраг, бүр зарим залуу судлаачид энэхүү буруу нэр томъёог зоригтой хэрэглэн, “бага ястнуудын эсрэг” утга агуулгатай зүйл ярьж байхыг сонслоо. Энэ бол баруун Монголчуудын хүний эрх, соёлын эрх ноцтой зөрчигдөж байгаагийн нэг илрэл мөн боловч үүнийг хүний эрхийн зөрчил гэж хүлээн зөвшөөрөхгүй байна.

Өөрсдийгөө бага ястан биш гэдгийг нударгаараа батлахыг оролдож байгаа залуу эрчүүдтэй би оюутан насандаа бишгүй л таарч байсан. Харин миний хандлага өөр байсан бөгөөд би өөрийн чадлаар Монголын түүхийн ном уншиж, энэхүү ялгаварлан гадуурхалтын үндэс шалтгааныг олохыг хичээж байсан юм. Бид бүгд адилхан Монгол үндэстэн гэдэгт би итгэж ирсэн. Одоо харин аливаа зүйлийг амжилтад хүрэхэд боловсролгүй хүмүүс л саад болдогийг мэдэж авлаа.

Саяхан Монгол улсын Ерөнхийлөгчийг Оросын Холбооны Улс, Халимагт айлчлал хийж байх үеэр Монголын алдартай нэгэн торгууд эрдэмтэн “Та Торгууд хэлээрээ ярьдаг уу?” гэж Халимагийн ТВ-ийн хөтлөгч олны танил Дөрвөд нэгэн хүнээс асууж байлаа. Энэ бол цаанаа “Та Торгууд хэлээрээ ярьдаг уу? Үгүй бол та жинхэнэ Халимаг хүн биш” гэсэн утгатай үг юм. Энэ үгний цаад утга санааг сайн ойлгосон миний анд Монголд амьдардаг “бага ястан” халимагуудын эсрэг чиглэсэн ийм ялгаварлалт Монголд байдаг эсэх тухай надаас дараа нь лавлаж байсан юм. Одоо бол “бага ястан” гэх энэхүү аман ярианы үг хэллэг Ойрадууд, баруун Монголчуудын эсрэг чиглэсэн ноцтой ялгаварлан гадуурхалтын эх сурвалж болоод байна уу гэж бодогддог. Саяхнаас Амарсанаа баатрыг хэдэн зуун жилийн өмнө өөрийн ард түмнийг айлган сүрдүүлж байсан дээрэмчин гэж хэлэх бүлэг хүн гарч ирлээ. Энэ бол

Монголчуудыг нэгэн тугийн дор нэгдэхийг таслан зогсоох гэсэн Манж Чин гүрний удирдагчдын явуулж байсан далд бодлогын цаад утга санаатай яг цав нийлж буй санаа сэдэл юм.

Хилийн чанадад амьдарч байгаа Монгол ахан дүүсдээ бид юу гэж хэлэх вэ? Тэднийг Монгол улсад зөвхөн үндэсний цөөнх гэж хүлээж авна гэж бид Оросын холбооны улсын Халимагууд, Хөлөн Буйр, Ордос, Алшаа нутгийн өөлдүүд, Хөх Нуурын хошууд түмэн, Шинжааны Дөрвөдүүд, Хятадын Торгуудууд, АНУ-ын Нью Жерси мужид амьдарч буй халимаг ахан дүүсдээ хэлэх үү? Одоо Улаанбаатар хотод ажиллаж, амьдарч байгаа Бямба Чужаев хэмээх халимаг хүн өөрийн өмнөх долоон үеийг төвөггүй нэрлэж чаддаг. Монголчуудын ихэнх нь дөнгөж гурван үеэ чүү ай мэддэг хэрнээ өөрсдийгөө Монголын баруун, хойд болон баруун хойд нутагт амьдардаг “бага ястан” цөөнхүүдээс илүү чухал монгол хүн гэж боддог.

“Бага ястан” гэж нэрлэгддэг баруун Монголчууд уламжлалт зочломтгой ёс заншлаа огт мартаагүй бөгөөд бүхий л зүйлийг өвөг дээдсийн тогтоосон дэг жаягийн дагуу хийхийг хичээж, шударга, хөдөлмөрч хичээнгүй, эх орныхоо төлөө цохилох зүрх сэтгэлээ хэвээр нь хадгалж ирсэн. Тиймээс энэхүү хандлагыг өөрчлөн, дараа дараагийн үедээ дамжуулан бататгахын эсрэг тууштай зогсох ёстой гэдэгт би бат итгэлтэй байна. Монгол бол олон овог аймаг, үндэстэн ястныг нэгэн тугийн дор нэгтгэн, нэгдсэн уламжлал болон түүхээрээ тэднийг, ялангуяа залуу үеэ хүмүүжүүлэн боловсруулж ирсэн улс юм.

Ихэнх Монгол хүнийг багагүй төөрөгдөлд оруулж байгаа энэхүү буруу нэр томъёо өнөөгийн Өвөр Монголын нутаг болох Улаан Будаг гэдэг газар Манжийн хаан Ойрадын баатруудад ялагдаад буцсанаас хойш баруун Монголын Ойрад түмний эсрэг манжуудыг ашиглаж байсан нэр юм. Ойрадын хан, язгууртнуудын зүгээс хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан Манжийн хаан ойрдуудыг Манжийн эсрэг зуун жил байлдаж

байгаа, өөрийг нь хуурч мэхэлсэн боол, дээрэмчид зэргээр нэрлэж байжээ. Харин их түүх маань үнэнийг заримдаа ил, заримдаа далд хадгалах боловч ямар ч байсан Монголын уламжлалт уйгаржин бичиг нөгөө л “Увс хэлээр” өгүүлж байдгийг бид бэлхнээ харж байна.

Миний хүсэлтээр хэл шинжээч профессор Самбуу ах “миний эх Монгол хэл” гэдгийг уйгаржин монгол бичгээр галигласан байдлаар нь дуудаж өгөхөд “өбэр ун Монгол хэлэн” гэсэн нь орчин цагийн Монгол хэл дээр бол “өөрийн Монгол хэл” гэсэн үг юм. Баруун Монголчууд, Ойрадууд үүнийг “эврээн Монгол кэлн” гэж дуудах бөгөөд үүнийг Орос, АНУ-ын халимагууд, Хятадын Дөрвөд, Өөлд, Хошууд, Торгууд хүмүүс шууд ойлгоно. Ойрадууд бол Монгол удмын овог аймаг бөгөөд ойрд хэл бол эртний Монгол хэл гэдгийг бид бүгд мэдэж байгаа. Олон улсын болон дотоодын эрдэмтэд үүнтэй бүгд санал нийлдэг ч Монголчуудын дунд зөв мэдээлэл тараагүй тул өргөн олон нийт сайн ойлгохгүй байгаа нь үнэн.

Баруун Монгол, Ойрадын түүх, соёлыг судалдаг хэн бүхэн өөрийн бодлыг нээлттэй хуваалцаж, энэ асуудлаар саналаа хэлэхийг би уриалж байна. Энэ нь Монголын баруун бүс нутгийнхан, цаашилбал, гадаадад амьдарч байгаа Монгол цустай хүмүүсийн хүний эрхийг хамгаалахад үнэлж баршгүй хувь нэмэр болно. Зарим хүн монгол хэлийг “Халх аялга, хэл” гэж нэрлэдэг ч би үүнийг саяхнаас кирилл цагаан толгойн нөлөөн дор хөгжиж бүрэлдсэн орчин цагийн монгол аялга гэж ойлгож байна.

Би Шилийн гол аймгийн нэгэн хүнтэй ярилцаж байхдаа Өвөр Монгол аялгыг сонсоод юуны түрүүнд л “эдний монгол хэлэнд хятад хэл хүчтэй нөлөөлж дээ” гэж бодож билээ. Харин 2006 онд Халимагт зочлох үеэр миний энэ бодол өөрчлөгдсөн юм. Шилийн голын Өвөр Монгол залуу “мадан, тадан” гэсэн үгээр бид, бидний, та нар, таны гэсэн санааг илэрхийлж байсан юм. Үүнийг би жинхэнэ монгол хэлний үг биш гэж

бодсон боловч Халимагуудын ярианаас буруу бодож байснаа ойлгосон юм. Орчин цагийн монгол хэлээр ярьдаг хүмүүс монгол хэлний эртний үг, хэллэг, дуудлага, найруулгынхаа заримыг мартжээ.

Орчин үеийн Монголчууд бид тусгаар тогтносон Монгол улсад эрх чөлөөтэй амьдарч байгаагаараа бахардаг. Харин бид бие биенээ, бүр бусад улс оронд амьдарч байгаа ахан дүүсээ хүндэтгэх ёстой гэдгээ ойлгох ёстой. Харамсалтай нь, олон залуу хүн интернэтээр ялгаварлан гадуурхалт, бүтээлч бус маргаанд өөрсдөө ч анзааралгүй татагдан орсоор байгаа бөгөөд сэдэв нь дээр дурьдсан “бага ястан” гэсэн нэр томъёог тойрч гарах нь ховор. Залуучуудын ихэнх нь “бага ястан” гэх нэр томъёог улс төрийн асуудлаар саналаа хэлэх, эсвэл алдартай хүн юмуу сонинд гарсан нийтлэл, бүр бөхийн тэмцээний тухай маргахдаа хэрэглэдэг. Нөгөө “Халх Монгол” гэж өөрийгөө нэрлэдэг хүмүүс л “бага ястны” асуудлыг эхлэн хөндөж, Монголоос гарч явах ёстой гэж бодогоо хэлдэг.

Энэ хүмүүсийг ингэхэд хүргэж байгаа зүйл юу вэ? Буруу ойлголт, түүхийн мэдлэг дутуу явдал л ийм байдалд хүргэж байгаа бөгөөд хүмүүс ном унших нь багасаж, Монголын их хаадын бий болгож өгсөн уламжлалт хуучин зарчмуудаа баримтлан дагахаа больжээ. Монголыг том бөгөөд дэвшилтэт үндэстэн гэж харахгүй хүн гарч болох л юм. Бүх Монгол хүн энэ тухай мэддэг ч дээрх нэр томъёоны зөв тайлбар, ойлголтын талаар нухацтай ярьж байгаа хүн, ялангуяа улс төрийн мэтгэлцээний үеэр гарахгүй байна. Харамсалтай нь энэ байдал Монголын бүх салбар, олон хүнд нөлөөлөх юм.

Энэ байдлыг засан залруулж, зөв тийш нь залахын тулд юу хийж болох вэ? Монгол хэл бичгийн хөгжил, өөрчлөлт, ахиц дэвшлийг ойлгохгүй байгаа хүмүүст итгэл үнэмшил төрүүлэхэд эрдэмтэн, судлаачид, түүхч, хэл шинжээч нар илүү их үүрэг хүлээх хэрэгтэй болж байна. Энэ асуудлын нарийн ширийн, гүн гүнзгий рүү нэвтэрч, Монгол нутагтаа амьдарч



байгаа Монгол хүн ялгаварлагдан гадуурхагдах ёсгүй гэдгийг Монгол улсын өнцөг булан бүрт амьдарч байгаа баруун Монгол, Ойрад хүмүүс, дэлхий нийтэд мэдүүлээсэй гэж би хүсэж байна.

Эрдэмтэн судлаач, олон нийтийн зүтгэлтэн, түүхчид болон Монголын бурханы шашны томоохон зүтгэлтэн Ажаа Гэгээн, Халимагийн Шажин лам Тело Түлкү ринбүчи нарт энэ чухал сэдвийг танилцуулах боломжийг надад гаргаж өгсөн уг хурлын зохион байгуулагч нарт гүн талархал илэрхийлье.

Хурал зохион байгуулагчдад хамгийн сайн сайхныг хүсэн ерөөхийн ялдамд ардчилсан Монгол улсад оюун санааны илүү өргөн эрх чөлөөг хүсье.